

## **ЗАГАЛМАЙГААР ДАМЖИН ЭРХ ЧӨЛӨӨНД ХҮРЭХ НЬ**

Үүнийг уншиж байх үедээ та бухимдалтай байж магадгүй. Хүмүүс таныг уналтанд хүргэсэн ба Бурхан танаас хэт хол юм шиг байж магадгүй. Та өсөх насандаа өөрийнхөө хүссэнээр хайрлагдаж байгаагүй байсан ч байж магадгүй. Эсвэл та өөрийгөө хэзээ ч хүлээн зөвшөөрдөггүй юмуу хэзээ ч хайрлаж байгаагүй ч байж магадгүй.

Амьдралдаа зохицож чадахгүй өөртөө итгэлгүй хүн зүсэн зүйлийн юм үзэж сэтгэлээр гутарч заримдаа амиа хорлохыг ч завддаг. Үүнээс болоод таны хайрладаг хүмүүстэйгээ харилцах харилцаа чинь тасрах тийшээ хандаж эсвэл бүр тасарсан ч байж магадгүй. Энэ бүхэн эргээд засрах найдваргүй ч байж магадгүй. Хэрэв та туйлын цөхрөлд орсон бол энэхүү мэдээ нь танд зориулагдсан юм.

Бурхан танд хайртай учраас Өөрийн Хүү, Эзэн Есүс Христийг таны гэмийн төлөө загалмай дээр үхүүлээд Түүнийг амилуулахаар явуулсан ба энэ нь таны ялгуусан бялхам амьдралын хэрэгцээг Түүгээр дамжуулан хангахын тулд билээ. Түүний үхэл таны гэмийг үнэ төлбөргүй өршөөгдөх Бурханы нөхцөлийг хангасан гэдэгт та эсвэл итгэнэ, эсвэл үгүй. Хэрэв үгүй бол энэхүү энгийн мэдээ, дүрсэлсэн диаграммын хамт таны амьдралыг өөрчилж та Эзэн Есүс Христийн амьдралыг авах юм.

Та Христэд өөрийнхөө авралын төлөө итгэж байсан байж болох юм. Мөн та тэмцэж байгаад ялагдсан Христич амьдралдаа ялалт байгуулах замыг хайж буй итгэгч байж болох юм.

Хэрэв эдгээрийн аль нь ч таны амьдралд тохиолдоогүй бол Библиэ нээгээд танд зориулагдсан эдгээр үнэнийг Бурхан гэгээрүүлэн таниулж өгөөсэй хэмээн залбираад зүрх сэтгэлээ нээлтэй байлгаж дараах зүйлсийг судлаарай.

### **Таны зохиомж**

Доорх диаграмм дээр хүн сүнс, сэтгэл ба махан бие гэсэн гурвалаар оршдог гэдгийг харуулсан. /1 Тесалоник 5:23/. Махан биеийнхээ мэдрэмжээр дамжуулан бид орчинтойгоо харилцдаг. Сэтгэл буюу бие хүн нь оюун ухаан, хүсэл ба сэтгэл хөдлөлөөс бүрддэг. Сэтгэл нь бидний хоорондын харилцааг бий болгодог. Биднийг өөрчлөгдөн дахин төрөөд Ариун Сүнсстэй болсон үед Сүнс бидний чадвар, сул тал болон нөхцөл байдлыг маань өөд татдаг.

Сүнс нь эсвэл Адам буюу Сатаны гэр бүл /диаграммыг харна уу/ эсвэл Христ буюу Бурханы гэр бүлтэй хамаатай байдаг. Бид Адам ба түүний төрхнөөс авч энэ ертөнцөд төрсөн. Энэ нь бидний сүнс Бурханы хувьд үхмэл, харин Сатаны хувьд амьд байна гэсэн үг. Харамсалтай нь бид буруу гэр бүлд байдаг! Нэгэнт бидний амь анхны эцэг буюу Адамаас өгөгдөж түүний амьдралын тасраагүй гинжин хэлхээнд хамаатай байдаг учраас бид гэм нүгэл хийдэг ба түүн дотор л байдаг. Ийнхүү бид хүн болж төрөхөөсөө өмнө

нүгэлтэн байдаг. Ийм учраас бидний үйлдэж буй гэм нүгэл бол байгаалаас заяагдсан зүйл. /Ром 3:23/ Адам дотор байгаа амь бүхэн гарцаагүй Тамд очдог /диаграммыг харна уу//Ром 6:23/ Бид сайн сайхан амьдарсан ч гэсэн хүний хувьд Бурханы гэр бүлд сүнсээр дахин төрж ороогүй л бол Бурханаас холдсон байдаг.

## Таны хэрэгцээ

Дугуй диаграммд байгаа “**Аврал**” /1/ гэсэн үг нь бид сүнсний хувьд дахин төрөх ёстой гэсэн утгыг агуулдаг. Тэгж л байж бид Адамын амьдралыг орхин Христийн амьдралд төрж мөнх амьтай болно. Дугуй диаграммыг харна уу /Иохан 3:3/. Сүнсээрээ дахин төрөхийн тулд бид буруу амьдарч байна, тиймээс нүгэлтэн болсон тэрхүү нүглийн үр дүн нь зайлшгүй юм гэдгийг хүлээн зөвшөөрч гэмших ёстой. Тэгээд бидний гэрийн төлөө үхсэн учраас Христийг өөрсдийнхөө амьдралд хүлээн авах ёстой.

Сүнсээр төрөхдөө Христийн Сүнсний амьдралыг өөрсдийнхөө сүнсэнд оруулсан хүмүүс итгэлээрээ Түүнтэй нэг сүнсэтэй болдог. /1 Коринт 6:17/ Тэд өөрсдийнхөө амьдралд сорилтыг даван ялж, Бурханы амар тайвныг мэдрэхийн тулд авралынхаа баталгаатай байх ёстой. **Баталгаа** /2/ нь Бурханы гуйвшгүй Үгний үнэмлэхүй дээр суурилдаггүй бол хоромхон зуур таныг орхидог.

Эзэн Есүс Христэд итгэдэгээ оюун ухаанаараа мэддэг олон хүмүүс аврагдсан гэдгээ мэдрэхгүй байдаг учраас тэдэнд жинхэнэ баталгаа дутсаар л байдаг. Бүр багаас нь үүдсэн сэтгэл ханамжгүй байдлаас болж хүний үзэл санаа буюу сэтгэлийн хөдлөл нь бодит байдалтай эвлэрэх нь хэцүү байдаг. Тийм хүмүүс Библид байдаг баримт юм уу бодит ертөцөд оршиж байгаа гэдэгтэйгээ ч зохицох нь ховор байдаг. Христийг өөрсдийнхөө амьдралын төвд оруулж сэтгэлийн шархаа эдгээх хүртэл бидний юмсыг хүлээж авах үзэл маань бодит байдлаас өөр байгаа мэт байдаг.

Шинэ итгэгч хүн юм уу хуучин итгэгч хүн аль аль нь Эзэн Есүс Христээр дамжин Бурхантай харилцах аюулгүй, мөнхийн сүнслэг харилцаанд орж байгаагаа мэдэх ёстой. Тэгснийхээ дараа л тэрээр өөрийнхөө хамгаалалтад /3/ найдаж түүндээ сэтгэл хангалуун байж чадна.

Олон итгэгч Христийг хүлээж авсанаа мэддэг боловч Түүн дотор хүлээн зөвшөөрөгдсөн гэдгээ ойлгохгүй, мэдрэхгүй байгаа нь цөөхөн байдаг. Олонх нь хүмүүний байр сууринаас хүлээн зөвшөөрөгдөх гэж зүтгэдэг. Тэд өөрсдийнхөө Христэд амьдралаараа бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн боловч Бурханд мөн хүлээн зөвшөөрөгдөх /4/ ёстой гэж боддог /Эфес 1:6/. Итгэгч бүр хүлээн зөвшөөрөгдсөн. Гэвч олонх нь өөрсдийнхөө хүлээн зөвшөөрөгдсөн ба зөвт байдлыг хэзээ ч итгэлээрээ хүлээн зөвшөөрдөггүй /2 Коринт 5:21/.

Эзэн Есүс Христэд амьдралаа бүрэн зориулдаг /5/ дэи цөөн байдаг. Энэ бол бид өөрийгөө бүрэн зориулж, биднийг, биднээр, бидэнд, бидэн дотор юу хүссэнээ хийж

байхыг Бурханд бүрэн зөвшөөрөх, эргэлт буцалтгүй шийдвэр гаргахыг хэлж байгаа юм. Бид өөрсдийнхөө бүхий л эрхээс татгалзаж байгаа юм.

Амьдралыг маань бүрэн хянах бидний хүсэлтийг Бурхан дээдлэн үздэг учраас иймэрхүү шийдвэр гаргасны дараа голдуу нөхцөл байдал маань замбараагаа алддаг. Хэрэв Бурхан хяналтагдаа авах юм бол бид өөрсдөө хяналтаа орхих ёстой. Харин энэ нь бидэнд баяр баясгалан авчрах нь ховор байдаг. Бидний амьдралд хяналтнаас маань гарах ёстой нөхцөл байдал юм уу юмс маань гол төлөв сүнснийх биш байдаг. Заримдаа эдгээр нь биднийг хүсээгүй зовлонд унагадаг боловч харин энэ зовлон бидний амьдралд зориулсан Бурханы сайн хүслээр дуусгавар болдог. /1 Петр 2:20,20. Филиппой 1:29,30/. Зовох юм уу сахилгажуулаётын цагт /Филиппой 3:10, Еврей 12:11/ баяр баясгалан амсах нь ховор юм шиг боловч бидний хүсэн хүсэж буй ариун байдлыг бий болгодог нь чухал юм. Бурхан итгэгчийг Христийн дүр төрхөд нийцүүлэх зорилготой байдаг. /Ром 8:29/. Ийнхүү нийцүүлэхийн тулд зовлон эдлэх хэрэгтэй болдог. Ром 8:28-д байдаг “бүх юмс” нь сайн сайхны төлөө хамтдаа ажилладаг боловч өөрсдөд нь сайн сайхнаар харагдах нь ховор байдаг. Энэ нь харин эргээд харахад л мэдрэгддэг.

### **Таны дотоод зөрчилдөөн**

Дугуйн дундах “а” гэдэг нь өөрийгөө хянах амьдрал буюу “махан бие”-ийг хэлж байгаа юм. Махан бие бол ихэнх итгэгчдийн Христийн амьдралд давамгайлж байдаг. Махан бие юм уу өөрийгөө хянах явдал давамгайлах үед хувь хүнээсээ шалтгаалан махан бие нь түүний хэрэгцээг ямар нэгэн юмаар эсвэл хүнээр сөрөг ба эерэг байдлаар хангах янз янзын зам хайж байдаг. Мөнгө, материаллаг зүйлс, ололт амжилт, алдар цуу, секс, эрх мэдэл, хүч чадал зэрэг тоо томшгүй олон зүйлс хүнийг жолоодох юм уу зоригжуулан урамшуулж анхаарлынх нь төв болж байдаг. Ийнхүү махан бие бол итгэгч хүний өөрийнхөө хүч чадалд итгэн Христөч амьдралаар амьдрах цэвэр оролдлого байдаг.

Ийм учраас махан бие Христөч хүний хувьд ноцтой асуудал болдог. Яг шүтээн шүтэх шиг. Яагаад гэвэл Христ дээр төвлөрөх байдлаа өөр юмаар орлуулбал, өөрийгөө ч гэсэн амьдралынхаа хаан суудалдаа тавьж бүдий л юм шүтээн болдог. Бурхан махан биеийн хувьд хатуу хандах ёстой. Үнэхээр ч тийм байдаг. Өөртөө төвлөрсөн нэгнийг амьдралын зовлон дунд яах ч аргагүй болтол нь залхааж эцэст нь бууж өгөөд өөрийн хүч чадлаар юу ч хийж чадахгүйг нь харуулж Христийн амьдралаар өөрийнхөө амьдралыг солиход хүргэдэг.

Өөрөө буюу махан бие амьдралыг хянаж байгаа цагт дугуй Диаграммд харуулсан сэтгэл /хувь хүн/ зөрчилдөөнд ордог. Нас ахих тусам энэ нь улам дордож үүрэг хариуцлага нь ихэсдэг. Сэтгэл зүйн хувьд сайтар төлөвшсөн хүний өөрийнхөөрөө амьдрах нь ховор тохиолдолд нөхцөл байдалтай зохицдог боловч гарах үр дүн нь санаанд нь огт хүрдэггүй рi.

Сэтгэл зүйн ялгаа нь гэм буруутай хамт /бодит ч бай, төсөөлөл ч бай/ өөрсдөө хянадаг амьдралд олон янзын гутрал бий болгодог. Эдгээр гутралыг даван туулах хэрэгтэй. Зарим нь үүнийгээ бие юм уу үгээр бусад руу цацдаг. Харин зарим нь хариу үйлдлээс эмээж дайсагналаа аль болохоор дарж тэвчдэг. Зарим нь ямар нэгэн асуудал гарч, бусдын дургүйцлийг төрүүлсэндээ өөрсдийгөө буруутгадаг учраас уур хилэн, гутралаа дардаг. Дайсагнал сэтгэл гутралыг дарах нь ямар ч шалтгаантай байсан ялгаагүй хэн хэнийх нь оюун ухаан юм уу сэтгэл хөдлөлд нөлөөлдөг. Дайсагнал юмуу уураа дотроо байлгаад байвал сэтгэл зовнил бий болгож сэтгэлийн дарамтанд оруулдаг. Зарим хүмүүс бодит байдлыг гуйвуулах юм уу үгүйсгэхийн тулд өөрсдийнхөө оюун ухааныг ашигладаг. Тэгснээрээ тэд бодит асуудлыг шийдэх болон өөрсдийнхөөрөө амьдрах шаардлагаас зугтаж байдаг.

Сэтгэл зүйн зөрчилдөөн ямарч эдгэрэлгүйгээр сунжран гол төлөв байнгын гоморхол болж хувирдаг /диаграммыг хар/. Бие махбодийн зовиур бодит боловч үнэндээ улам гүнзгий асуудлын шинж тэмдгүүд буюу өөрийн санаагаар амьдрахад хүргэдэг. Сэтгэл зүйн асуудлууд ийнхүү сэтгэлийн талбарт илэрдэг.

### **Таны чөлөөлөлт**

Өөр дээрээ төвлөрсөн амьдралыг Бурхан хаан суудлаас нь буулгаж үндсэн асуудлыг шийдэж байгааг харснаар л эдгээр сэтгэл зүйн ба бие махбодийн шинжүүд алга болж эхэлдэг.

Шулуун шугамын диаграмм нь Бурханы “үхлээс амь руу” гэсэн зарчмыг харуулдаг. Энэ нь дотоод зөрчлөдөөнөөс ангижрах Бурханы арга замыг харуулсан байдаг.

Хэвтээ шугам нь мөнх амь, Христийн мөнх амийг харуулсан. Мөнх гэдэг маань эхлэл, төгсгөлгүй гэдгийг тодорхойлж байгаа юм. Энэ нь цаг хугацааны зах хязгаарыг давж байгаа юм. Христ бол Бурхан учраас үргэлж амьд байгаа, амьд байх ч болно. Түүний амьдрал бол өчигдөр, өнөөдөр, үүр мөнхөд байдаг /Еврей 13:8/. Шугамын зүүн хэсэгт нь Христ “махан бие” болсныг дүрсэлсэн /Иохан 1:14/. Тэрээр хүмүүний биеэр 33 жил амьдарсан. Дараа нь Тэрээр цовдлуулан, булшинд ороод үхсэнээс хойш гуравдахь өдөр нь амилуулагдсан. /1Коринт 15:3,4/. Тэрээр өнөөдөр ч амьд байгаа /Еврей 7:25/. Мөнх амьдрал бол итгэгчийн одоогийн ба ирээдүйн бодит байдал байгаад зогсохгүй мөн үүрд мөнхийн өнгөрсөн цаг билээ.

Дахин төрөх хүртлээ бид Христийн буюу мөнх амьдралд байдаггүй /Иохан 3:3/ ба бид Адамын үхмэл амьдралд байдаг. Бидний амьдрал бол Адам дотор эхэлдэг бол түүнд тохиолдсон юм бүхэн бидэнд ч тохиолддог. Түүнийг гэм хийхэд бид ч гэм хийсэн. Түүнийг сүнсний хувьд үхэхэд бид ч мөн үхсэн. Яг л өвөг эцэг дотроо үхсэн шиг. Ийнхүү, нэгэнт сүнсний үхэл нь Бурханаас тусгаарлагдан холдуулж байгаа учраас бид бүгд сүнсний хувьд үхмэлээр төрсөн байдаг. Бид гэм нүгэл хийснийхээ төлөө уучлагдах хэрэгтэй, мөн бидэнд амь хэрэгтэй. Эзэн Есүс Христ бидэн дээр ирж аль алинийг нь өгсөн.

Бидний гэм нүглийн төлөө үхсэнээрээ ч бидэнд Өөрийнхөө амилсан амиа өгснөөрөө ч тэр.  
/Иохан 10:10/

Хэрэв та Христэд бол үүнийг мэднэ. Харин та нар юуг мэдэхгүй вэ гэвэл:

Итгэгч хүний хувьд үхэл бол ертөнц болон гэмт оршихуйгаас Мөнхийн улс болон Бурханы оршихуй руу орох үүд хаалга юм. Үүн шиг нөгөө төрлийн үхэл бол Адамын гэмт амьдралаас Христийн мөнх амь руу орох үүд хаалга юм. Дахин төрсөн хүн бол яг үүн шиг үхдэг. Тэр Христийн амьдралд төрөхийн зэрэгцээ Адамын амьдралаас үхэж байгаа юм.

Христ бидний амьдралд ирээд бид Түүнд итгэж дахин төрдөг. Гэхдээ үүгээр дуусгавар болдоггүй. Бид Түүний амийн буюу мөнхийн амийн оролцогчид болдог. Ром 6:3-д бид зөвхөн Есүс Христ /Түүний амь/ руу баптисм хүртээд зогсохгүй Түүний үхэл рүү ч мөн адил баптисм хүртдэг. Бид эсрэг тэсрэг хоёр амийг /Адамын ба Христийн амь/ нэгэн зэрэг авч болохгүй.

### **Таны тодорхойлолт**

Бид итгэлээрээ Христийг хүлээн авахад Түүний загалмай дээрх үхэл нь бидний өрийн төлөөс юм шиг санагддаг. Гэвч энэ нь үүнээс хамаагүй их зүйлийг агуулдаг. Энэ нь бид өнгөрсөн ба ирээдүйг маань үүрә мөнх болгосон шинэ амьдралд орж байгаа гэсэн үг. Өөрөөр хэлж бид Адам доторх түүхээ /сайн муугаа/ Христ доторх мөнхийн түүхээр сольж байгаа юм. Бид гэр бүлийн шинэ модыг өвөлж авч байгаа юм. Христийн амьдралд ороёцогч болсноор бид Түүний үхэл, оршуулга, амилалт, өргөлтөд оролцож тэнгэрийн суудалтай болж байгаа юм / Ром 6:3-6, Галат 2:20, Эфес 2:6/. Түүнд ганц л амь байдаг ба бид шинээр төрөхдөө түүнийг нь хүлээн авдаг / 1 Иохан 5:11,12/.

Христтэй хамт цовдлогдсоноо хувийнхаа итгэлээр мэдэх хүртлээ бид өмнөх өөрийнхөөрөө амьдарч байхдаа сурсан арга барилаараа Христийн төлөө амьдрахыг оролддог. Адам дотор амьдарч байсан түүхээс үүдсэн зөрчилдөөнүүд биднийг зовоосоор, дийлсээр байх болно. Харин бид итгэлээрээ, үхэл ба амилалтаараа Христтэй нэгдэж Загалмай дээр өөрсдийнхөө зөвт байдлыг эзэлсэн цагт л зөвхөн тэр үед л бид шинэ амьдрал дотроо үнэнхүү алхаж чадна /Ром 6:4а/. Хуучин юмс улиран өнгөрсөн, үзэгтүн юмс шинэ боллоо гэсэн цагт л. /2 Коринт 5:17/

Загалмайн туршлага нь /Христтэй хамт цовдлуулаад амилах туршлагыг ойлгосноороо /Сүнсээр хянуулсан амьдралд хүрэх үүд хаалга болдог /Галат 5:16/. Энэ бол үхлээс амь, ялагдлаас ялалт бөгөөд итгэгчийн амьдрал дахь зовлон зүдгүүрийн зорилго ба хариулт юм. Загалмайд хүрэх бидний зам, мөн Загалмай өөрөө зовлон зүдгүүрийн зам боловч зовлонгийн төгсгөлд хүрэх цорын ганц зам билээ.

Танд дотоод зөрчилдөөн их байдаг уу? Итгэлээрээ түүнийг даван туулах гэсэн оролдлого чинь байнга ялагдал хүлээдэг үү? Та Түүний төлөө амьдрахын тулд өөрийнхөө

хувьд бүрэн үхэхэд бэлэн үү? Үүний тулд та өөрөө удирддаг амьдралаа Христийн амьдралаар сольж Ариун Сүнсээр дүүрэн байж, Түүгээр удирдуулж байх ёстой. Үүнээс татгалзах юм бол та махан биеийнхээ төлөө явсаар зөрчилдөөн, зовлон шаналал ба ялагдал хүлээн Сүнсийг гутаах болно.

### **Авралын гуйлт**

Хэрэв та өөрийнхөөрөө юмсыг хийснээсээ үүдэн гар÷ буй зовлон шаналлаасаа залхаж байвал Христ таныг чөлөөлнө. Харин та Түүнд чин сэтгэлээсээ бүх юмсыг даатгах хэрэгтэй.

Та Христийг Өөрийнхөө Аврагчаар хэзээ ч хүлээн авч байгаагүй бол өөрийгөө сүнсний хувьд дахин шинээр төрүүлэхийг Бурханд зөвшөөрөх ёстой. Та үнэн сэтгэлээсээ дараах гуйлтуй хийж залбирах юм бол дахин төрөх болно.

*Тэнгэрлэг Эцэг минь ээ. Би өөрийгөө гэм нүгэлтэй ба Адамын амьдралаар амьдарч нүгэл үйлдсээр байгаагаа ойлголоо. Та Өөрийнхөө цорын ганц Хүү Эзэн Есүс Христийг миний гэмийн төлөө миний өмнөөс үхүүлэхээр явуулсанд итгэж байна. Мөн Тэрээр амилаад одоо ч амьд байгаа гэдэгт итгэж байна. Тиймээс би яг одоо Түүнийг сэтгэл зүрхэндээ оруулж өөрийнхөө Аврагчаар хүлээн авч байна. Би өөрийгөө, өөртөө байгаа бүхнээ, цаашид ч байх бүхий л зүйлсээ Тандаа зориулж байна. Би өөрийнхөө гэм нүгэл ба зөвхөн өөрийгөө гэсэн амьдралаасаа эргэн буцаж Христ дотор шинэ амьдралаар амьдрана. Намайг аварсанд тань баярлалаа. Амен.*

### **Тодорхойлогч залбирал**

Хэрэв та авралын гуйлт хийсэн бол та шинээр төрж байгаа юм. Учир нь Христэд итгэсэн хүн бүрт Бурхан Өөрийнхөө хүүхэд болох давуу эрхийг өгдөг. /Иохан 1:12/ Та авралын гуйлтаа дөнгөж хийсэн ч байж болно, эсвэл өмнө нь хийчихсэн байж ч болно харин та одоо ялалт, амар тайван бүхий Христийн амьдралаар явахын тулд дараах гуйлтыг хийх хэрэгтэй. Залбирал тань үр дүнтэй байхын тулд та одооныхоо өөртөө найдсан амьдралаасаа залхсан байх ёстой. Мөн өөрийнхөө хүчинд найдан Христèч амьдралаар амьдрах оролдлого чинь буруу гэдгийг Ариун Сүнсээр ятгуулсан өөрөө амьдралаа хянах явдлаас татгалзахад бэлэн байх ёстой. Хэрэв та ийм байдлалд байгаа бол дараах гуйлтыг хий:

*Аав минь, миний гэм нүглийг уучилж Адамын амьдралаас салгаж Христийн амьдралд оруулсан явдалд баярлалаа. Одоо би Христ дотор байгаа ба Түүнтэй хамт цовдлуулан, булшинд ороод Түүнтэй хамт амилуулагдаж Түүнтэй хамт Таны баруун гар талд сууж байна гэдэгт итгэж байна. Энэ цагаас Таны Хүү Есүс Христийг өөрийнхөө дотор байлгаж, Түүний амьдралаар амьдрахаа сонгож байна. Би өөрийгөө гэм нүглийн хувьд үхсэн гэж үзэж байна. Христтэй хамт үхсэнээ умартаж хүмүүний мэргэн ухаан ба хүч чадлаар амьдрах гэсэн тэр үед надад сануулж байхыг Ариун Сүнсэнд даатгаж*

*байна. Би өөрийгөө зөвт байдлын зэмсэг болгож гэм нүгэлд унах ямар ч юмыг амьдралдаа үлдээхгүй байх болно. Христ болон Түүний амьдралыг надад бодит болгож өгсөн Танд баярлалаа. Надаар дамжуулан Өөрийгөө алдариуулж байх болтугай. Амен.*